



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/331

Мөрөн сум

Барилгын ажил хүлээж авах комисс
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6 Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын гудамж талбайн гэрэлтүүлэг, индэрийн засварын ажил хүлээж авах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Энхжаргал
(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:
Ж.Жавзанпагма
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн Архивын тасгийн дарга)

Х.Даваасүрэн
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн,
Ерөнхий архитектор)

Д.Мягмарсүрэн
(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилга техник
хяналтын улсын байцаагч)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:
Н.Даваахүү
(“Хөвсгөл мичид” ХХК-ийн Захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:
Д.Идэрмөнх
(Мөрөн сумын Засаг даргын албан үүргийг түр орлогч
гүйцэтгэгч)

Ш.Баасанпүрэв
(Мөрөн сумын Архитектор, дэд бүтэц, нийтийн тээвэр
хариуцсан мэргэжилтэн)

Комиссын нарийн бичгийн дарга: Б.Баасанжав

(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
мэргэжилтэн)

2. Барилгын ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилгын ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилгын ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН